



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ**

Амраллын гудамж 1-103, 3-р баг, Дэлгэрцогт сум,  
Дундговь аймаг 48110 Утас: 88597484  
Цахим хаяг: delgerisogtith@gmail.com  
Цалин хувиар: www.dundgovi.gov.mn

2022.06.22 № 16

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ Л.ЗОЛЖАРГАЛД

**Зөвлөмж хүргүүлэх тухай**

Суманд 2022 онд ОНХСангаар хийгдэхээр батлагдсан ажлуудад ИТХ-ын төлөөлөлөөс хяналт явуулахад ажлуудын сонгон шалгаруулалт хууль, журмын дагуу явагдаж ажлуудын гүйцэтгэлийн чанар сайн, мөн хагас жилийн эд хөрөнгийн тооллогоос өмнө гүйцэтгэгдсэн хөрөнгүүдийг ИТХ-ын тогтоолоор бүртгэлд авсан байна.

Цаашид анхаарах:

- 2021 оны Малын тоо толгойн албан татвараас төвлөрөх хөрөнгөөр хийгдэх ажил цаг хугацаа алдсанаас он дамжиж байсанг давтахгүй байх.

- ОНХС-ын хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгүүдийн эзэмшигчийг тодорхой болгон хариуцуулж, ажиллагааны зардлын хариуцагчыг нь тодорхой болгож ажиллахыг зөвлөмж болгож байна.

ДАРГА

П.ТҮВШИНСАЙХАН



2022 оны ОНХС-ын хөрөнгөөр хийгдэж буй ажлуудад  
сумын ИТХ-ын төлөөлөлөөс гүйцэтгэлийн явцад хяналт хийсэн талаарх товч мэдээлэл.

1. Бог малын чанрыг сайжруулах төсөл арга хэмжээг "Чавчирын өлгий" бүлэг гүйцэтгэж байгаа бөгөөд гүйцэтгэлд хяналт хийхэд "Сайнцагаан" болон "Баянцагаан" омгийн хонины хээлтүүлэгчээр 3 багийн малд сайжруулалт хийх зорилгоор 60 хээлтүүлэгч аваад намар нийлүүлэхээр бэлэн болсон ажлын явц 60 хувьтай байна гэж үзлээ.
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Цагаан нуур"-ын бог малын ванныг сэргээн засварлах ажлыг "Баянбулаг" бүлэг гүйцэтгэж, ажлын явцтай танилцахад мал унагаж хөвүүлдэг хэсгийг томруулж, гүнзгийлж байсан бөгөөд цэвдэг хад чулуу шавар ихтэй байна энэнд ажлын цаг хугацаа алдаж байгаа талаар бүлгийн ахлагч В.Амаржаргал танилцууллаа. Хашаануудыг блокоор барьж гүйцэтгэлийн чанар сайн байлаа.
3. Сумын Эрүүл мэндийн төвд 8.0 сая төгрөгийн үнэ бүхий Биохимийн апаратыг Монбиофрам ХХК шууд гэрээгээр нийлүүлсэн. Үйл ажиллагаа хэвийн зохих журмын дагуу ашиглагдаж байна.
4. Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэгийн ажлыг сонгон шалгаруулалтын аргаар Смарт контрол ХХК нь Алтанзагас хороолол болон Эрчимийн өргөн гудамыг гэрлийг чанар стандартын шаардлагад нийцүүлэн тавьсан ажиллагаа хэвийн байна. Урсгал зардлын асуудлыг тухайн хороололын ерхүүдтэй тохиролцож шийдвэрлэсэн байна.
5. Мал угаалгын ванн болон мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зөөврийн хашааны ажлыг "Дрийм Финал Дизайн" ХХК нь харьцуулалтын аргаар сонгогдон Жарамтайн мал угаалгын хуучин ванны дэргэд шинээр гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн энэ үйл ажиллагаанд нь гүйцэтгэлийн хяналт 2-3 тавьж ажиллаа. Гүйцэтгэлийг сайн байна гэж хяналт хийсэн төлөөлөгч нар үзэж зөвлөмж хүргүүлэхээр боллоо.

ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хийсэн: .....

Мөнхзориг / П.Мөнхзориг /

А.Амартүвшин / А.Амартүвшин /